



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/26

Хужирт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын “Спорт заалны шал засвар ӨВАХУСЗДТГ/202201006” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Л.Цэдэв - Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга: Д.Норов - 3 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч
Гишүүд: Д.Уранчимэг - Санхүүгийн албаны дарга
Б.Бямбасүрэн - Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
С.Гэрэлт- Од - Иргэний төлөөлөл (зөвшилцснөөр)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга (Л.Цэдэв)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Норов)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ